



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 11 өдөр

Дугаар А/285

Арвайхээр

Нэмэлт гэрээ байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4.1, Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2, 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр суманд баригдаж буй Музейн барилгын төсөвт өртөгт нь Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар нэмэгдэж батлагдсан тул гүйцэтгэгч “Бага хөгшин” ХХК-тай байгуулсан барилга угсралтын гэрээний үнэд тохируулга хийж нэмэлт гэрээ байгуулсугай.

2. Гэрээ байгуулж гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т даалгасугай.

3. Нэмэлт гэрээнд шаардагдах 991,000,000 (есөн зуун ерэн нэгэн сая) төгрөгийг Сангийн яаманд уламжлан шийдвэрлүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100608

D:My Doc. Zahiramj. Zasag darga